



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/02/НА-СТА-ТБОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллагын үйл ажилагаа	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан	8
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
4.4 Материаллаг байдал	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДХ	Ардын депутатын хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

1.Аудитын санал дүгнэлт



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

“СУАТ” ХХК ОНӨААН-ИЙН
ЗАХИРАЛ Ж.АДАЛБЕК ТАНАА

2022.03.15 № 321
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын баталсан заавар аргачлалын дагуу бэлтгэсэн бөгөөд санхүүгийн тайланд холбогдох мэдээллийг бүрэн толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалттай холбоотой хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Суат ХХК-Дүгнэлт

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Суат ХХК-Дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,401,937.22	773,714.74
1.1.2	Дансны авлага	74,738,789.90	221,130,096.58
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	77,056,585.12	300,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	39,150,281.18	50,992,647.74
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,389,742.94	12,310,193.85
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	213,737,336.36	285,506,652.91
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,960,386,558.30	6,797,052,388.14
1.2.2	Биет бус хөрөнгө	1,056,361,000.00	1,063,478,199.98
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,016,747,558.30	7,860,530,588.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,230,484,894.66	8,146,037,241.03
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	337,274,547.90	283,801,667.05
2.1.1.2	Цалингийн өглөг	337,274,547.90	283,801,667.05
2.1.1.3	Татварын өр	79,484,675.31	36,167,875.95
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	236,173,897.70	234,506,312.30
2.1.1.6	Хүүний өглөг	21,615,974.89	13,127,478.80
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	337,274,547.90	283,801,667.05

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	991,058,656.00	991,058,656.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

**“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	991,058,656.00	991,058,656.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,328,333,203.90	1,274,860,323.05
2.3	Эздийн өмч	6,902,151,690.76	6,871,176,917.98
2.3.1	Өмч:-төрийн	3,295,181,962.17	3,295,181,962.17
2.3.2	· хувийн		
2.3.3	· хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,505,765,988.90	4,505,765,988.90
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(898,796,260.31)	(929,771,033.09)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,902,151,690.76	6,871,176,917.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,230,484,894.66	8,146,037,241.03

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	969,513,261.47	1,245,059,684.66
2	Борлуулалтын өртөг	969,513,261.47	1,070,484,500.00
3	Нийт ашиг(алдагдал)	-	174,575,184.66
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	168,157,081.12	205,549,957.44
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(168,157,081.12)	(30,974,772.78)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(168,157,081.12)	(30,974,772.78)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(168,157,081.12)	(30,974,772.78)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

**“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,652,416,530.00		4,505,765,988.90		(684,423,847.47)	6,473,758,671.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны зааврлал	(77,355,193.83)					(77,355,193.83)
3	Залруулсан үлдэгдэл	2,575,061,336.17	-	4,505,765,988.90	-	(684,423,847.47)	6,396,403,477.60
4	Тайлант үеийн цэвэр ашиг(аюуллага)					(214,372,412.84)	(214,372,412.84)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт	720,120,626.00					720,120,626.00
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(898,796,260.31)	6,902,151,690.76
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны						-
11	Залруулсан үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(898,796,260.31)	6,902,151,690.76
12	Тайлант үеийн цэвэр ашиг (аюуллага)					(30,974,772.78)	(30,974,772.78)
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт						-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(929,771,033.09)	6,871,176,917.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	980,817,575.76	1,239,948,710.14
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	980,817,575.76	1,239,948,710.14
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	945,484,194.27	1,219,021,632.62
	Ажиллагчдад төлсөн	371,636,351.00	376,881,939.58
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	135,083,326.87	142,994,383.19
	Бараа материал худалданавахад төлсөн		25,330,221.81
	Ашиглалтын зардалд төлсөн	143,601,201.48	309,749,181.34
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,276,790.00	64,128,735.05
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	21,260,053.24	132,733,424.95
	Даатгалын төлбөрт төлсөн		5,194,650.00
	Бусад мөнгөн зарлага	263,626,471.68	162,009,096.70
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		

**“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	29,141,955.00	29,555,300.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Мөнгөнзарлагын дүн (-)		
2.3	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,141,955.00	29,555,300.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Мөнгөнзарлагын дүн (-)		
3.3	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,191,426.49	(8,628,222.48)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,210,510.73	9,401,937.22
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,401,937.22	773,714.74

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Борлуулалтын орлого	Төгрөг	364,700,000.00	383,599,688.00	471,637,240.00	88,037,552.00	22.9
	Борлуулалтын орлого бохир ус	Төгрөг	361,100,000.00	372,591,254.00	422,791,820.00	50,200,566.00	13.5
	Борлуулалтын орлого халуун ус	Төгрөг	156,900,000.00	156,865,819.00	148,280,514.50	(8,585,304.50)	5.8
	Борлуулалтын орлого бусад	Төгрөг	40,700,000.00	40,656,980.00	202,350,109.66	161,693,129.66	
2	Нийт орлого		923,400,000.00	953,713,741.00	1,245,059,684.16	291,345,943.16	42.2
3	Нийт зардал		1,137,700,000.00	1,139,423,341.00	1,276,034,456.94	136,611,115.94	44.4
	Үүнээс						
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	Төгрөг	969,500,000.00	988,413,300.00	1,070,484,500.00	82,071,200.00	8.3
	Ерөнхий ба удирдлагын зардал	Төгрөг	168,200,000.00	151,010,041.00	205,549,956.94	54,539,915.94	36.1
	Хөрөнгө ба удирдлагын засвар	Төгрөг					
4	Цэвэр ашиг, алдагдал		(214,300,000.00)	(185,709,600.00)	(30,974,772.78)	154,734,827.22	(2.19)

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажилагаа

“Суат” ХХК-нийн зорилго нь: Хэрэглэгчдийг ундны ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар найдвартай хангаж хэрэглээний явцад гарсан бохир усыг татан зайлуулж, хөнгөн шуурхай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Өлгий сумын хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн ундны ахуйн цэвэр усаар хангах, гарсан бохир усыг зайлуулан цэвэрлэх, нийтийн халуун усаар үйлчлэх, инженерийн байгууламжийн жигд найдвартай ажиллагааг хангах, гарсан авар ослыг богино хугацаанд арилгаж усны алдагдлыг багасгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Суат” ХХК нь анх 1952 онд АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дэргэд “Үйлчлэх товчоо” нэртэйгээр байгуулагдаж, 1999 онос бүтцийг өөрчилж “Суат” ХХК нэртэйгээр байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэж байна.

“Суат” ХХК -ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 5.1 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд хийгдсэн арга хэмжээ байхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин

төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 1.7 сая төгрөгөөр буюу 0.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Тайлант онд санхүүгийн үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор “Микролайнс” ХХК-ниас борлуулалтын багц программыг 3.8 сая төгрөгөөр, “Ординат” ХХК-ниас “Юникус” санхүүгийн цогц программыг 3.9 сая төгрөгөөр тус тус худалдан авч ашиглаж байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Суат” ХХК-ны тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тус компаний захирлын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж ажилласан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,401.9	773.7	(8,628.2)
БХХО	-	-	-
Авлага	151,795.4	221,430.1	69,634.7
Урьдчилгаа	13,389.7	12,310.2	(1,079.5)
Бараа материал	39,150.3	50,992.6	11,842.4
Үндсэн хөрөнгө	6,960,386.6	6,797,052.4	(163,334.2)
Биет бус хөрөнгө	1,056,361.0	1,063,478.2	7,117.2
Нийт хөрөнгийн дүн	8,230,484.9	8,146,037.2	(84,447.7)
Өр төлбөрийн дүн	1,328,333.2	1,274,860.3	(53,472.9)
Богино хугацаат өглөг	337,274.5	283,801.7	(53,472.9)
Урт хугацаат өглөг	991,058.7	991,058.7	-
Эздийн өмч	6,902,151.7	6,871,176.9	(30,974.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,230,484.9	8,146,037.2	(84,447.7)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал данс, хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.7 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс кассын үлдэгдэл 0.2 сая, 0.5 арилжааны банкны мөнгөн үлдэгдэлтэй байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 1.1 сая төгрөгөөр буурсан.

Авлагын дансны үлдэгдэл 221.4 сая төгрөгөөр буюу 69.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрийн хүрээнд үүссэн айл өрх, ААНБ-аас авах авлага 130.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа 213.9 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 7.5 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Авлага дансны үлдэгдэлд 2011 оноос хойш үүссэн, үйл ажиллагаа нь зогссон, дампуурсан аж ахуйн нэгжтэй холбоотой олон жил болсон 7.5 сая төгрөгийн авлага байгааг найдваргүй авлагын дансанд бүртгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60.0 сая төгрөг болж 11.8 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын үлдэгдэл 10.5 сая, БҮТЭЗ-ийн материал 2.6 сая төгрөгөөр үлдэгдэлтэй байгаа нь худалдаж авсан материал үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Тайлант онд 22.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 17.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч нийт 39.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 163.3 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 29.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан, аймгийн ОНХС-гаас 30.0 сая төгрөгийн суудлын автомашины үнэ төлбөргүй хүлээн авч нийтдээ 59.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 94 дүгээр тогтоолоор 1986 оноос хойш үлдэгдэлд байсан 80 нэр төрлийн 80 ширхэг 404.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 135 нэр төрлийн 195 ширхэг 45.1 сая төгрөгийн тавилга эд хогшил нийтдээ 449.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, акталсан хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэнтэй хамтарч устгалын комиссын дүгнэлтээр устгал хийж баримтжуулсан байна.

Биет бус хөрөнгө 7.8 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан программ байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 283.8 сая төгрөг болж 53.5 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

НӨАТ-т 222.3 сая, ХХОАТ-т 8.4 сая, ус ашигласны төлбөрт 3.9 сая, НДШ-д 13.1 сая, халаалтын зардалд 11.1 сая, гэрэл цахилгаанд 23.5 сая, үйлдвэрчний эвлэлийн татварт 1.5 сая, нийтдээ 283.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд байгаа 991.0 сая төгрөг нь 2001 оноос хойш үүссэн төслийн өр ба тайлант онд ямар нэг төлөлт хийгдээгүй байна.

Энэ нь Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймагт цэвэр бохир усны системийн техник, технологийг шинэчлэх цэвэр усны шугам хоолойг өргөтгөх, цэвэр бохир усны насосын станц, 30 хүний халуун усны барилгад их засвар хийх, 3 ба 5 хүний халуун ус барих, ус түгээх, 2 ш гүний худаг барих, машин техник нийлүүлэх, цэвэрлэх байгууламжид био цөөрмийн карт барих зэрэг ажлуудад хийгдсэн хөрөнгө оруулалт байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал гэж ангилсан байна. Зардлыг өмнөх онтой харьцуулахад нийт зардал 138.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, тээвэр шатахууны зардлууд нэмэгдснээс шалтгаалжээ.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Суат” ХХК-нийн гүйцэтгэх захирал нь байгууллагын

үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлөөс компани 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй, орон тоо, цалингийн санг баталсан байна.

Харин “Суат” ХХК-ны зүгээс “Хот суурны ус хангамж ариутгах татуургын зохицуулах зөвлөл”-д 2021 оны санхүүгийн төлөвлөгөөг хүргүүлж, батлуулсан байна.

“Суат” ХХК-ны 2021 оны нийт орлогыг 953.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 1139.4 сая төгрөгөөр, 185.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 29.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1245.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1276.0 сая төгрөгийн зардал гарган, -30.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гүйцэтгэлээр нийтдээ 1245.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 291.4 сая төгрөгөөр буюу 30.5 хувиар давж биелэгдсэн нь хэрэглэгчдийн тоо нэмэгдсэнээс шалтгаалж усны хэрэглээ нэмэгдсэн, төсөвт байгууллагын үнэ тариф өөрчлөгдсөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Компаний нийт зардлын гүйцэтгэл 1276.0 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 136.6 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар хэтэрсэн байна. Үүнд ажилчдын цалин нэмэгдсэн, үнэ ханш нэмэгдсэнтэй холбоотой тээвэр шатахуун, цахилгаан, түлш халаалтын зардал, бусад зардал нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

“Суат” ХХК нь тайлант онд 30.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг төлөвлөснөөс 154.8 сая төгрөгөөр бууруулсан байна. Энэ нь 2021 онд борлуулалтын орлого 30.5 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Борлуулалтын орлого өмнөх 275.5 сая төгрөгөөр буюу 28.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос цэвэр, бохир усны орлого өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 37.4 сая төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос цалин хөлс, гэрэл цахилгаан, тээвэр шатахууны зардлууд өссөн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалт дагуу Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн шалгалтаар 3 төрлийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. Үүнээс компаний ажилчдын цалин хөлсийг Орон сууцны нийтийн аж ахуйн салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 4.2 -т заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох /588000 төгрөг/-нөөс дээгүүр тогтоож, биелэлтийг ирүүлэх талаар албан шаардлага өгсний дагуу хөдөлмөрийн хөлснөөс доогуур цалинтай 56 ажилтны цалинг 12 хувиар буюу 12.0 сая төгрөгийн цалинг 2021 оны 9 дүгээр сарын 01-нээс нэмэгдүүлэн олгосон байна.

Компани Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 07 тоот тогтоолоор компаний захирлын үндсэн цалинг 1.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна. Тайлант онд компаний захирлын тушаалаар 4.1 сая төгрөгийг ойн арга хэмжээ, шагнал урамшуулал олгох, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалд зарцуулсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 20 нэр төрлийн шугамын урсгал за свар хийж, өөрийн хөрөнгөөр 45.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Компани нь тайлант онд НДШ-ийн ногдуулалтын алдангид 6.1 сая төгрөгийг, татварын өглөгийн алдангид 2.7 сая төгрөгийг, Шүүхийн шийдвэрээр харуул хамгаалалтын

компанид 5.2 сая төгрөгийг, нийтдээ 14.0 сая төгрөгийг төлж төлөвлөгдөөгүй, үр ашиггүй зардал гаргасан байна.

“Суат” ХХК нь Засгийн газраас төрөөс хариуцсан цэвэр, бохир усны төлбөрөөс авлагаар бүртгэсэн 130.3 сая төгрөгийг тайланд онд авч, дээрх үр ашиггүй зардлуудыг гаргаагүй байсан бол санхүүгийн тайлангаар ашигтай гарах боломж байсан байна.

Тус компани нь 3, 5, 30 хүний халууны усны үсчин, 2 халуун усны байрны түрээс, хуучин конторын барилгын 2 өрөөг түрээсийн гэрээгээр өгч түрээсийн орлого оруулдаг байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Засгийн газрын 2020 оны Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын дагуу цэвэр, бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөр дамжуулан тайлант онд Төр хариуцах цэвэр бохир усны төлбөрт айл өрхөөс 294.6 сая, аж ахуйн нэгж байгууллагаас 218.9 сая, сумдын төлбөрт 76.1 сая төгрөгийн нийтдээ 589.6 сая төгрөгийн цэвэр, бохир усны төлбөрийг нэхэмжилснээс 459.2 сая төгрөгийн санхүүжилт авч 130.3 сая төгрөгийн дутуу авсан санхүүжилтийн хэмжээгээр санхүүгийн тайланд авлагатай гарсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Суат” ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

“Суат” ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 16-ний өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

“Суат” ХХК-д эдийн засагч, дотоод аудиторын 1 орон тоо ажилладаг бөгөөд тайлант онд 10 ажил хийхээр төлөвлөгөө батлуулж, гүйцэтгэлээр 7 ажилыг хийж 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажилладаг байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Суат” ХХК-ны 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн ба Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын хэлтэсээс төлөвлөгөөт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Суат” ХХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны байдлын тайлангийн нийт хөрөнгө 8230.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 164.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 115.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 28 мэдээллээс сар бүр оруулах батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 9 сарын 2069.7 сая төгрөгийн орлого, зарлагын мэдээлэл, тухай бүр оруулах хөрөнгө оруулалт тендер худалдан авалтын Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллээс 8, улирал бүр оруулах Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллээс 3 улирлын мэдээлэл нийт 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 улирлын мэдээллийг оруулаагүй, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтсан тул албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус компаний 2021 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 122.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4.5 сая төгрөгийн зөрчилд 2 заалттай зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийг давтан шалаж үзэхэд төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлт хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	703.3	1	703.3	-	-	-
Албан шаардлага	2	122635.0	2	122635.0	-	-	-
Зөвлөмж	2	4551.3	1	4551.3	1	-	-
Нийт дүн	5	127889.6	5	127889.6	1		

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар өмч, хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2162.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2069.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 91.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2162.1 сая төгрөгийн алдаа зөрчлийн шилэн дансны зөрчлийн 2069.8 сая төгрөгийн хасаж тооцвол тогтоосон 92.3 сая төгрөгийн түвшинээс 115.2 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

- Байхгүй

8.2 Төлбөрийн акт

Аудитаар 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 07 тоот тогтоолоор компаний захирлын үндсэн цалинг 390.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1690.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 11, 12 дугаар сард 819.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1-д “Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай”, 1.3-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

8.3 Албан шаардлага

Аудитаар 2069.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 28 мэдээллээс сар бүр оруулах батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 9 сарын 2069.7 сая төгрөгийн орлого, зарлагын мэдээлэл, тухай бүр оруулах хөрөнгө оруулалт тендер худалдан авалтын Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллээс 8, улирал бүр оруулах Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллээс 3 улирлын мэдээлэл нийт 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 улирлын мэдээллийг оруулаагүй, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд борлуулалтын орлого, сар бүрийн түрээсийн орлогоос нийтдээ 91.5 сая төгрөгийг касст бэлнээр орлого авч, банкин дахь харилцах дансанд тушаахгүйгээр шууд зарцуулсан.

Өгсөн зөвлөмж:

Борлуулалтын болон түрээсийн орлогыг зөвхөн банкин дахь харилцах дансанд тушааж тооцоо хийх, кассаас бэлнээр шууд зарцуулалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Суат ХХК	БӨА-2022/02/НА-СТА-ТБОНӨААН	“Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 07 тоот тогтоолоор компаний захирлын үндсэн цалинг 390.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1690.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 11, 12 дугаар сард 819.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.	Төлбөрийн актын барагдуулах	1	819.0			1	819.0						
2			Тайлант онд борлуулалтын орлого, сар бүрийн түрээсийн орлогоос нийтдээ 91.5 сая төгрөгийг касст бэлнээр орлого авч, банкин дахь харилцах дансанд тушаахгүйгээр шууд зарцуулсан.	Борлуулалтын болон түрээсийн орлогыг зөвхөн банкин дахь харилцах дансанд тушааж тооцоо хийх, кассаас бэлнээр шууд зарцуулалт хийхгүй байх.	1	91,479.1									1	91,479.1
ДҮН					2	92,298.1			1	819.0					1	91,479.1
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Суат ХХК	БӨА-2022/02/НА-СТА-ТБОНӨААН	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 28 мэдээллээс сар бүр оруулах батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 9 сарын 2069.7 сая төгрөгийн орлого, зарлагын мэдээлэл, тухай бүр оруулах хөрөнгө оруулалт тендер худалдан авалтын Хөрөнгийн болон урсгал	Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, шилэн дансны нэгдсэн	1	2,069,755.2					1	2,069,755.2				

**“Суат” хязгаарлагдмал хариуцлагатай компани ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан**

		зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллээс 8, улирал бүр оруулах Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллээс 3 улирлын мэдээлэл нийт 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 улирлын мэдээллийг оруулаагүй, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.	цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулах												
		ДҮН			1	2,069,755.2					1	2,069,755.2			
		НИЙТ ДҮН			3	2,162,053.3			1	819.0	1	2,069,755.2			1 91,479.1